



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 142

Улаанбаатар хот

Г Компанийн үлгэрчилсэн журмуудыг Г
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Компанийн дараах үлгэрчилсэн журмуудыг хавсралтаар баталсугай:

- 1/ “ТУЗ-ийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журам”-ыг 1 дүгээр хавсралтаар,
- 2/ “ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үлгэрчилсэн журам”-ыг 2 дугаар хавсралтаар,
- 3/ “ТУЗ-ийн цалин урамшууллын хорооны үлгэрчилсэн журам”-ыг 3 дугаар хавсралтаар,
- 4/ “ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны үлгэрчилсэн журам”-ыг 4 дүгээр хавсралтаар,
- 5/ “ТУЗ-ийн аудитын хорооны үлгэрчилсэн журам”-ыг 5 дугаар хавсралтаар,
- 6/ “Хувь нийлүүлэгчдийн хурлын үлгэрчилсэн журам”-ыг 6 дугаар хавсралтаар.

2. Улсын Их Хурлаас 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Компанийн тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан уг хуулийн хэрэгжилтийг хангахдаа энэхүү тогтоолоор батлагдсан үлгэрчилсэн загвар журмуудыг ашиглахыг зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолын 1-д заасан үлгэрчилсэн журмууд нь заавал биелэгдэх эрх зүйн хэм хэмжээ агуулаагүй ба компани нь Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн өөрийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинээр боловсруулахад эдгээр загвар журмуудыг удирдлага болгохыг дурдсугай.

4. Энэхүү тогтоолыг нийт компаниудад мэдээлж, сурталчилж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000275